

## СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАР

### ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГЫН ТӨРИЙН ТУСГАЙ АЛБАН ТУШААЛД АНХ ОРОХ ИРГЭНЭЭС АВАХ МЭРГЭШЛИЙН ШАЛГАЛТЫН ЗАР

Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлөөс Цагдаа, Дотоодын цэргийн байгууллагын төрийн тусгай албан тушаалын сул орон тоог нөхөх, нөөц бүрдүүлэх зорилгоор Ховд аймаг дахь Цагдаагийн газар ЦАГДАА-ЖОЛООЧ ажлын байранд сонгон шалгаруулалтыг нээлттэй зарлаж, мэргэшлийн шалгалтыг 2019 оны 03 дугаар сарын 25-31-ний дотор өдрүүдэд зохион байгуулах гэж байна.

Ажлын байр /албан тушаал/-д тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа иргэд өрсөлдөхөөр бүртгүүлэх эрхтэй бөгөөд бүртгэл 2 үе шаттай явагдана. Үүнд:

Иргэд 2019 оны 03 дугаар сарын 07-ны өдрөөс 2019 оны 03 дугаар сарын 17-ны өдрийг хүртэл хугацаанд бүртгүүлж, судалгаанд хамрагдаж, шалгалтад орох эрх олгоно.

**Иргэд дараах бичиг баримтыг бүрдүүлж, бүртгэл, судалгаанд хамрагдана. Үүнд:**

- -Өргөдөл
- -Биеийн байцаалт (Төрийн албан хаагчийн биеийн байцаалтын маягт №1-ийн дагуу бүрэн бичсэн байх);
- -Бүрэн дунд, Дээд боловсролын диплом, сурагчийн хувийн хэрэг; /нотариатаар баталгаажуулсан хуулбарын хамт/
- -Иргэний үнэмлэх; /нотариатаар баталгаажуулсан хуулбарын хамт/
- -3 үеийн түүх;
- -Оршин суугаа хаягийн тодорхойлолт;
- -Цэргийн үүрэгтний үнэмлэх /нотариатаар баталгаажуулсан хуулбарын хамт/
- -3x4, 4x6 хэмжээний 4% зураг;
- -Ажиллаж байсан бол ажилласан хугацаа болон ажил эрхлэлтийг гэрчлэх баримт /нийгмийн даатгалын дэвтэр, хөдөлмөрийн дэвтэр/-ийн эх хувь; албанаас чөлөөлөгдсөн бол тушаалын хувь; архивын лавлагаа,
- -Эмчийн орон тоонд өрсөлдөх иргэдийн хувьд хүчин төгөлдөр эмчлэх эрхийн гэрчилгээ; /нотариатаар баталгаажуулсан хуулбарын хамт/

Шаардлагатай гэж үзвэл иргэнээс нэмэлт материал гаргуулан авна.

**Сул орон тоонд өрсөлдөх иргэдийн анхаарах зүйлс. Үүнд:**

- Шалгалтад орохоор бүртгүүлж байгаа иргэн өөрийнхөө тухай үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй.
- Бичиг баримт дутуу бүрдүүлсэн, зарлагдсан ажлын байранд тавигдах шаардлагыг хангаагүй иргэдийг судалгаанд хамруулахгүй.

- Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад бүртгүүлж, судалгаанд хамрагдаагүй иргэд шалгалтад орох эрх олгохгүй.
- Эрүүл мэндийн үзлэгийг Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэгийн нарийн мэргэжлийн эмч нарын комисс хийх ба ЭХО, Сүрьеэ, Цээжний зураг /флюор жижиг/, Цусны дэлгэрэнгүй /элэгний үйл ажиллагаа/, Шээсний дэлгэрэнгүй шинжилгээ, ДОХ /БЗХӨ/, Элэгний В, С вирус, Зүрхний бичлэгийг урьдчилан Нийслэлд Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэгт, орон нутагт харъяа Нэгдсэн эмнэлэгт хийлгүүлж, шинжилгээний хариуг бэлтгэсэн байх.

Ажлын байр /албан тушаал/-д ерөнхий болон тусгай шаардлага, “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын төрийн тусгай албан тушаалд анх орох иргэнээс мэргэшлийн шалгалт авах журам”-ыг Цагдаагийн байгууллагын цахим хуудас [http://www.hrm.police.gov.mn/-д](http://www.hrm.police.gov.mn/) байршуулсан тул Та бүхэн бүртгэлтэй холбоотой болон холбогдох бусад дэлгэрэнгүй мэдээлэлтэй танилцана уу.

Мэргэшлийн шалгалттай холбоотой асуудлаар Цагдаагийн газрын Хүний нөөцийн мэргэжилтэний 99123596 дугаарын утсаар холбогдож, лавлагаа, мэдээлэл авч болно.

**ХОВД АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗАР**